

Монноос ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны тайлан

1. Үйл ажиллагаанууд

1.1) Монноос ХК нь 2020 онд Ковид-19 цар тахлаас шалтгаалан ноос угаах үйлдвэрлэл болон бусад үйл ажиллагаанууд төлөвлөсөн дагуу явагдах боломжгүй байсан болно.

1.2) Монноос ХК-ийн газар, байр, талбайг түрээслэн ажиллаж байсан 8 түрээслэгч үйл ажиллагаагаа зогсоосон бөгөөд 5 агуулах, 2 гаднах талбайн түрээслэл үргэлжилсэн болно.

1.3) Компанийн 2020 оны орлого зарлагын үзүүлэлтийг өнгөрсөн онтой харьцуулан үзүүлбэл:

Мян.төг

№	Үзүүлэлт	2019 он	2020 он	Зөрүү
1	Орлого	117,839.0	82,145.0	(-35,694.0)
2	Зарлага	116,532.5	76,729.3	(-39,803.0)
3	Ашиг (алдагдал)	(-1,306.5)	(-5,415.7)	

Өөрөөр хэлбэл 2020 онд орлого 35,694.0 мянган төгрөгөөр буурсан болно.

1.4) Монноос ХК нь түрээслэгч нартай түрээсийн төлбөр тооцоог сар бүр хийж төлбөрийг нэхэмжлэн авч байсан болно.

1.5) Өвлийн бэлтгэл ажлын хүрээнд гаднах инженерийн шугам сүлжээнд хэсэгчилсэн засвар үйлчилгээг хийж байсан болно.

1.6) Сар бүр ХУД-ын ТҮК-тэй хийсэн гэрээний үндсэн дээр хогийн цэгт хуримтлагдсан хогийг ачуулж байсан болно.

2. Монноос ХК-ийн 2020 онд хийхээр төлөвлөсөн ажлын биелэлт

2.1) Гаднах 20 метр уурын шугмыг шинэчлэн засварлаагүй энэ нь ноос угаах үйлдвэрлэл явуулах боломжгүй болсонтой холбоотой болно.

2.2) 8 давхар оффисын барилгын чанар байдлын дүгнэлтийг гаргуулж түүнд үндэслэн шаардлагатай засварыг хийлгэх ажил хийгдээгүй. Энэ нь санхүүжилтээс шалтгаалсан болно.

2.3) Оффис, харуулын байр, КНС-ын цахилгаан хангалтыг Орхон дээд сургуулиар дамжуулан “Ариг гал” ХК-ийн тэжээлийн шугамаас авах ажлыг гүйцэтгэсэн болно.

2.4) “Ковид-19” цар тахлаас шалтгаалан түрээсийн орлогыг нэмэгдүүлэх ажил хийгдээгүй болно.

3. 2021 онд төлөвлөж байгаа ажлууд

3.1) “Ковид-19” цар тахлын халдвар багасч хэвийн болсон нөхцөлд “Ноос угаах” үйлдвэрлэлээ сэргээнэ.

3.2) 10000 квт-ын хүчин чадалтай, алдагдал өндөр хуучин ЗХУ-д үйлдвэрлэсэн трансформаторыг хүчин чадал бага трансформатороор солих.

3.3) 8 давхар оффисд төлөвлөсөн дагуу засвар хийж ашиглах.

3.4) Боломжит байр, гаднах талбайг түрээслэж орлогыг нэмэгдүүлэх.

Тайлан бичсэн: Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/